

## АГААР БОХИРДУУЛАХ ЭХ ҮҮСВЭРИЙН 2017 ОНЫ ТООЛЛОГЫН ТАЙЛАН

2017.12.05

Алтай хот

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-181 дүгээр тушаалаар баталсан Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журмын дагуу аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Тус тоо бүртгэлийн ажлыг аймгийн төвд аймгийн Засаг даргын 2017 оны А/330 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, сумдад сумын Засаг даргын орлогч, БОХУБ, байгаль хамгаалагч, цаг уурын техникч, инженер, байгийн Засаг дарга нар хийлээ.

Сумдын тоо бүртгэлийн ажлыг БОАЖГ, УЦУОШГ-аас нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр бүрэн хангаж ажиллаласан бөгөөд тооллогын дүнг нэгтгэн журамд заасан хугацаанд Мэргэжлийн албанд хүргүүлэв.

Тооллогод 18 сум, 2 тосгоны зуух бүхий айл өрх, нам даралтын зуухнууд, тээврийн хэрэгсэл хамрагдсан бөгөөд 10 кВт хүртэл, 11-100 кВт хүртэл, 101-ээс дээш буюу 0.1 мвт-аас дээш хүчин чадалтай зуух гэсэн 3 ангиллаар тооллогыг хийж, тэдгээрт хэрэглэсэн түлшний судалгааг төрөл тус бүрээр гаргалаа.

**10 кВт хүртэл хүчин чадалтай зуух:** Аймгийн төвд гэрийн зуух 3404, хувийн орон сууцны зуух 444, нийт 3848 зуух тоологдож, эдгээрт нийт 7710 тн нүүрс, 5291 м3 мод, 2260.5 тн аргал, 888.3 тн хөрзөн, 11 тн үртэс болон бусад түлшийг хэрэглэсэн байна. Сумдад гэрийн зуух 3402, хувийн орон сууцны зуух 944, нийт 3193 зууханд 6958.1 тн нүүрс, 1481.1 м3 мод, 4843.4 тн аргал, 4989.4 тн хөрзөн, 53.2 тн үртэсэн болон бусад түлш хэрэглэсэн дүн мэдээ гарлаа. /Тус судалгааг төв суурин газарт байгаа эх үүсвэрээр гаргаав/

Багийн нэр	Гэрийн зуухны тоо			Гэрийн зууханд хэрэглэсэн түлшний хэмжээ, тн/жил					Нийт	Хувийн орон сууцны зуухны тоо					Хувийн орон сууцны зууханд хэрэглэсэн түлшний хэмжээ /тн/				
	Нийт	ердийн	бүрэн шаталттай зуух	нүүрс	мод /м3/	аргал	хөрзөн	Үртсэн		Ердийн зуух	ханан пийшин	Усан халаалттай	Бүрэн шаталт	Нүүрс	мод /м3/	Аргал	Хөрзөн	Бусад	
Баянхайрхан	648	562	86	1347	373	565,5	371,5		86			86		206	50	118	48		
Оргил	35	15	20	22	22	13	0.3	1.5	20	20				32	30,5	15	2,5		
Индэрт	565	482	83	1402	1760	481	271,4		68	1	47	20		260	246	66	39,9		
Жаргалан	408	351	57	707	650	52	23		55	6	35	14		132	101				
Түмэн	537	336	201	919	852	50	2		79	3	46	30		151	150	12			



НИЙТ	3402	2412	990	4783	873.2	3798	3977	10.7	944	463	232	141	104	4	2175	607.9	1046	1012	18.7
------	------	------	-----	------	-------	------	------	------	-----	-----	-----	-----	-----	---	------	-------	------	------	------

Хүснэгт 2. Сумдын гэрийн болон хувийн орон сууцны зуухны судалгаа

Тус онд аймгийн хэмжээнд 10 квт хүртэл хүчин чадалтай гэрийн зуух 6806, хувийн орон сууцны зуух 1388, нийт 8194 зуух тоологдож, 14668.1 тн нүүрс, 6772.1 м3 мод, 7103.9 тн аргал, 5877.7 тн хөрзөн, 64.2 тн үртэсэн болон бусад түлш хэрэглэсэн байна.

№	Сумд	Он	Айл өрхийн зуух		
			Гэр	Байшин	Жилд хэрэглэдэг нүүрсний хэмжээ тн
1	Есөнбулаг сумд	2014	3277	215	20450,2
		2015	2827	157	33478,0
		2016	2729	158	7650,9
		2017	3404	444	7710
2	Аймгийн хэмжээнд	2014	5834	312	26467,6
		2015	5698	214	43573,5
		2016	6480	350	17947,9
		2017	6806	1388	14668.1

Хүснэгт 3. 2014-2017 оны харьцуулсан судалгаа

**11 квт-аас дээш хүчин чадалтай зуух:** Тус онд 11-100 квт хүчин чадалтай усан халаалтын зуух аймгийн төвд 34, сумдад 187, нийт 221 ширхэг нам даралтын зуух тоологдож, 14418.1 тн нүүрс, 718 м3 мод, 8 тн бусад түлш хэрэглэсэн дүн гарсан бөгөөд 101 квт-аас дээш хүчин чадалтай зуух аймгийн төвд 3, сумдад 3 бүртгэгдэж, нийт 22730 тн нүүрс хэрэглэсэн дүн гарлаа.

№	Сумд	Усан халаалтын зуух /11-100 кВт/				Дулааны станц, уурын болон усан халаалтын зуух /100 кВт-с дээш/	
		Зуухны тоо	Нүүрс	Мод/м3/	Бусад	Зуухны тоо	Нүүрс
1	Есөнбулаг сумд	34	3254	-	-	3	20230
2	Сумдад	187	11164.1	718	8	3	2500
3	Аймгийн хэмжээнд	221	14418.1	718	8	6	22730

Хүснэгт 4. Усан халаалтын зуухны судалгаа

**Хөдөлгөөнт эх үүсвэр:** 2017 оны агаар бохирдуулах хөдөлгөөнт эх үүсвэрийн тооллогоор суудлын машин 7658, ачааны машин 3101, нийтийн тээврийн хэрэгсэл 38, тусгай зориулалттай 232, цистерн 127, зүтгүүр 33, нийт 11191 тээврийн хэрэгсэл тоологдлоо. Тээврийн хэрэгслийг насжилтаар нь авч үзвэл 0-3 жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 0.37 хувь, 4-6 жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 1.21 хувь, 7-9 жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 2.11 хувь

10 ба түүнээс дээш насжилттай тээврийн хэрэгсэл 96.31 хувийг тус тус эзэлж байна.

№	Сумдын нэрс	Зориулалт							Насжилт				Шатахууны төрөл						Угааны зэрэглэл					
		Нийт тээврийн хэрэгсэл	Суудал	Ачаа	Нийтийн тээвэр	Тусгай зориулалт	Цистерн	Зүтгүүр	0-3	4-6	7-9	10 ба түүнээс дээш	АИ-95	АИ-92	АИ-80	Дизель	Газ	Хосолсон	А	В	С	Д	Е	F
1	Алтай	475	326	114	2	11	13	9	2	14	17	440	26	74	263	100	3	9	2	4	17	105	0	0
2	Баян-Уул	482	299	159	0	20	4	0	1	2	5	476	24	124	147	171	2	14	33	81	84	9	2	0
3	Бигэр	267	176	84	0	4	3	0	2	1	4	259	16	67	73	102	0	9	2	7	21	2	0	1
4	Бугат	362	255	89	2	8	7	1	1	6	9	346	12	32	244	67	0	7	20	16	62	21	0	0
5	Гуулин	48	22	22	0	2	2	0	0	1	0	47	2	6	24	16	0	0	5	22	37	2	0	0
6	Дарви	349	226	112	0	10	0	0	0	2	3	344	29	57	146	108	0	9	19	64	121	9	1	1
7	Дэлгэр	565	298	251	0	11	5	0	3	1	4	557	36	138	96	262	1	32	9	43	82	9	0	1
8	Есөнбулаг	4791	3508	1107	33	85	40	18	18	75	126	4571	461	1578	1021	1266	30	435	340	400	433	138	13	57
9	Жаргалан	357	227	115	0	10	5	0	2	2	4	349	25	82	128	106	0	16	4	23	63	50	0	0
10	Тайшир	305	196	100	0	5	4	0	1	1	4	299	19	89	63	106	1	27	24	32	56	2	0	0
11	Төгрөг	373	237	126	0	3	6	1	1	5	6	361	23	67	139	135	0	9	15	112	55	12	0	3
12	Тонхил	372	247	116	0	6	3	0	1	1	7	363	15	43	205	102	0	7	4	4	25	7	0	0
13	Халиун	364	214	142	0	2	6	0	2	2	4	356	18	64	120	139	2	21	4	11	17	88	0	0
14	Хөхморьт	268	216	41	0	11	0	0	2	4	5	257	21	70	123	46	0	8	10	15	28	42	1	0
15	Цогт	457	306	134	0	13	4	0	3	4	4	446	22	43	270	115	1	6	2	3	17	159	1	2
16	Цээл	342	272	55	0	8	6	0	1	6	7	328	14	60	217	44	0	7	3	18	61	22	5	0
17	Чандмань	286	158	109	0	6	11	2	1	2	11	272	26	58	69	121	2	10	6	23	58	44	5	2
18	Шарга	380	259	111	0	6	2	2	0	3	10	367	36	68	111	132	1	32	12	33	110	15	0	1
19	Эрдэнэ	348	216	114	1	11	6	0	1	4	7	336	27	83	88	139	1	10	1	7	73	17	9	0
<b>Нийт</b>		<b>11191</b>	<b>7658</b>	<b>3101</b>	<b>38</b>	<b>232</b>	<b>127</b>	<b>33</b>	<b>42</b>	<b>136</b>	<b>237</b>	<b>10774</b>	<b>852</b>	<b>2803</b>	<b>3547</b>	<b>3277</b>	<b>44</b>	<b>668</b>	<b>515</b>	<b>918</b>	<b>1420</b>	<b>753</b>	<b>37</b>	<b>68</b>

Хүснэгт 5. Тээврийн хэрэгслийн судалгаа

Хөдөлгөөнт эх үүсвэрийг шатахууны төрлөөр авч үзвэл АИ-95 хэрэглэдэг тээврийн хэрэгсэл 7.61 хувь, АИ-92 хэрэглэдэг тээврийн хэрэгсэл 25.04 хувь, АИ-80 хэрэглэдэг тээврийн хэрэгсэл 31.69 хувь, дизель хэрэглэдэг тээврийн хэрэгсэл 29.28 хувь, газ хэрэглэдэг тээврийн хэрэгсэл 0.39 хувь, хосолсон хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 5.99 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд тус оны тооллого нь урд онуудаас бодитой дүн гарснаараа онцлог боллоо.

д/д	Он	Тээврийн хэрэгслийн төрөл					Зүтгүүр
		Суудал	Ачаа	Нийтийн тээвэр	Тусгай	Цистерн	
1	2014	1568	456	28	31	25	
2	2015	2930	940	24	77	38	
3	2016	3237	1038	31	82	55	
4	2017	7658	3101	38	232	127	33

Хүснэгт 6. 2014-2017 оны тээврийн хэрэгслийн тооллогын дүн

**Нэгдсэн дүн:** Тооллогоор тус онд 10 квт хүртэл хүчин чадалтай зуух 8194 зуух, 11-100 квт хүртэл хүчин чадалтай зуух 221 зуух, 101 квт-аас дээш хүчин чадалтай зуух 6 зуух, агаар бохирдуулах хөдөлгөөнт эх үүсвэр 11191 бүртгэгдсэн байна. Агаар бохирдуулан зуухнуудад 2017 онд нийт 51816.2 тн нүүрс, 7490.1 м3 мод, 7106.9 тн аргал, 5882.7 тн хөрзөн, 64.2 тн үртэс болон бусад түлшийг хэрэглэсэн дүн мэдээ гарсан байна.

**Дүгнэлт:** Тус оны тооллогоор 2016 оныхоос 10 квт хүчин чадалтай зуух 1364-р, 11-100 квт хүчин чадалтай зуух 16-р, 101-ээс дээш квт хүчин чадалтай зуух 1-р, хөдөлгөөнт эх үүсвэр 707-р нэмэгдсэн дүн гарсан байна. Ингэж агаар бохирдуулах эх үүсвэрийн тоо нэмэгдэж байгаа нь түүхий нүүрсний хэрэглээг нэмэгдүүлж, агаарын бохирдол, утаажилтыг улам ихэсгэж байгаа нэг шалтгаан болж байна.

Мөн нийт хэрэглэсэн нүүрсний 71.69 хувийг нам даралтын зууханд /*үүний 45.32 хувийг аймгийн төвд, 26.37 хувийг сумдад*/, 28.31 хувийг айл өрх/*үүний 14.88 хувийг аймгийн төвд, 13.43 хувийг сумдад*/ хэрэглэсэн байгаа бөгөөд үүнээс дүгнэхэд нам даралтын зуух, тэр дундаа 101 квт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуухны нүүрсний хэрэглээ их байгаа нь харагдаж байна. Түүнчлэн айл өрхийн түлшний судалгаанаас дүгнэхэд аймгийн төвийн айл өрхийн нүүрсний хэрэглээ сумдтай харьцуулахад их, харин сумдад аргал, хөрзөнгийн хэрэглээ аймгийн төвийнхөөс их, нүүрсний хэрэглээ бага байна.

Хөдөлгөөнт эх үүсвэрийн хувьд нийт тээврийн хэрэгслийн 42.81 хувь нь аймгийн төвд, 57.19 хувь нь сумдад төвлөрч байгаа бөгөөд үүнийг насжилтаар нь авч үзэхэд 96.31 хувийг 10-аас дээш насжилттай тээврийн хэрэгсэл эзэлж байна. Түүнчлэн нийт тээврийн хэрэгслийн 0.39 хувь нь байгаль ээлтэй газ хэрэглэдэг, 61.93 хувь нь байгаль орчинд хортой, 37.68 хувь нь дундаж хортой шатахуун хэрэглэж байна. Үү нээс дүгнэхэд нийт тээврийн хэрэгслийн 99.61 хувь нь агаарын бохирдолд нөлөө үзүүлж байна.

**Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:**

1. Аймгийн төвд дулааны цахилгаан станцтай байгуулж, сумдыг төвлөрсөн халаалтын системд шилжүүлэх замаар нам даралтын зуухнуудаас агаарын бохирдолд үзүүлэх нөлөөллийг бууруулах
2. Аймгийн төвийн гэр хорооллын айл өрхүүдийг орон сууцжуулах бодлого баримтлах, гэр хорооллын айл өрхүүд цахилгаан халаагуур тавихад дэмжлэг үзүүлэх
3. Хагас боловсруулсан түлшний хэрэглээг хэвшүүлж, түүхий нүүрсний хэрэглээг бууруулах
4. Шингээлт буюу ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх
5. Байгаль хор багатай шатахуун хэрэглэдэг тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх ажлыг дэмжих, насжилт өндөртэй тээврийн хэрэгслийн авто оношлогооны ажлыг чанаржуулах